МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР
А корпус, Засгийн газрын IX байр,
Энхтайваны өргөн чөлөө 16, Баянзүрх дүүрэг,
Улаанбаатар хот, 13381
Утас/Факс: (976-51) 26 00 62
Цахим шуудан: info@spa.gov.mn
Цахим хуудас: www.spa.gov.mn

СОНИРХОГЧ ЭТГЭЭДЭД

2025.04.23 № А-1/1426

танай_____-ны № _____-т

Тендерийн баримт бичигт өөрчлөлт оруулах тухай

Тус газраас зарласан ЭХЗЯ/20250103097 дугаартай "Ханги боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө /Өмнөговь, Хатанбулаг сум/" төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтад захиалагч Эдийн засаг, хөгжлийн яамнаас ирүүлсэн техникийн тодорхойлолтын дагуу тендер шалгаруулалтын баримт бичигт дараах өөрчлөлтийг оруулж байна.

Үүнд:

1. ТШЗ 19.1-т ажил гүйцэтгэх хүний нөөцөд нэмэлтээр тусгав.

2	Хот төлөвлөлтийн архитектор	1	Хот төлөвлөлтийн архитектор	5 жилээс доошгүй

2. ТШЗ 19.3 Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: Үйлчилгээ үзүүлэгч нь дараах тусгай зөвшөөрөлтэй байна.

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам:

4.1.Барилга байгууламжийн архитехтур, барилга бүтээцийн зураг төсөл, орчны тохижилт

4.4.Ус хангамж, ариутгах татуургын гол (магистраль) шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга, байгууламжийн технологийн ажлын зураг

4.5.Дулаан хангамжийн гол (магистраль) шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга, байгууламжийн технологийн ажлын зураг

4.10.Мэдээлэл холбоо дохиоллын дамжуулах (магистраль) болон салбар шугам сүлжээ түүнтэй холбогдох барилга байгууламжийн ажлын зураг

6.1.Барилга байгууламжийн дотор ус хангамж, ариутгах татуургын систем, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл

6.2.Барилга байгууламжийн дотор халаалт, салхивч, хөргөлтийн систем, гадна дулааны салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл

6.3.Барилга байгууламжийн дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамжийн систем, 35кВ хүртэлх гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл, орон сууц, олон нийт, үйлдвэрийн барилгын болон тоног төхөөрөмжийн хянах, хэмжих хэрэгсэл автоматикийн зураг төсөл

6.4.Барилга байгууламжийн дотор мэдээлэл холбоо, галын болон бусад дохиоллын системийн зураг төсөл, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологи, гадна салбар шугам сүлжээний зураг төсөл

7.1.Ус хангамж, ариутгах татуургын гол (магистраль) шугам сүлжээ, түүнтэй

холбогдох барилга, байгууламжийн технологийн ажлын зураг

7.2.Дулааны бие даасан 5.0 МВт хүртэлх эх үүсвэрийн барилга барилга байгууламжийн технологи, шугам сүлжээний зураг төсөл

7.4.Мэдээлэл харилцаа холбоо дохиоллын гол (магистраль) шугам сүлжээ түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл гэснийг тус тус хасч

Зөвшөөрлийн тухай хууль:

Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн

3.6-д заасан “газар зохион байгуулалтын үйл ажиллагаа явуулах мэргэжлийн байгууллагын эрх олгох”,

3.8-д заасан “хот байгуулалтын баримт бичиг боловсруулах” гэж тус тус өөрчлөв.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11.12-т заасны дагуу Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д дээрх өөрчлөлтийг тусгасан тендерийн баримт бичгийг шинэчлэн байршуулсан болно.

ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР
УДИРДЛАГА
ДАРГА
Ц.БАТЗУЛ
2025.04.23 16:23